



ЭМ, ЭМНЭЛГИЙН ХЭРЭГСЛИЙН ХЯНАЛТ,
ЗОХИЦУУЛАЛТЫН ГАЗРЫН ДАРГЫН
ТУШААЛ

2022 оны 05 сарын 17 өдөр

Дугаар А/104

Улаанбаатар хот

Хуулийн хэрэгжилт хангуулах,
чиглэл өгөх тухай

Засгийн газрын агентлагийн эрх зүйн байдлын тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1.1, 8 дугаар зүйлийн 8.3.1, Захиргааны ерөнхий хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1, 40.2, Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.1, 16.5.4, 16.5.5, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 2 дугаар бүлгийг үндэслэн ТУШААХ нь:

1.Төрийн хэмнэлтийн тухай хууль үйлчилж эхэлсэнтэй холбогдуулан тус хуулийн судлан мөрдөж, бага зардлаар ажлын үр дүн бүтээмжийг сайжруулж, хууль тогтоомжийн дагуу төрийн зардлыг хэмнэж ажиллахыг нийт албан хаагчдад үүрэг болгосугай.

2.Тушаалын хэрэгжилт, Төрийн хэмнэлтийн хуулийн хүрээнд өдөр тутмын үйл ажиллагаанд хяналт тавьж, зохион байгуулалт хийж ажиллахыг нийт газар хэлтсийн дарга нарт даалгасугай.

3.Төрийн хэмнэлтийн хуулийн хүрээнд дээд газарт тайлагнах тайлан мэдээг хугацаанд нь гаргаж хүргүүлж байхыг Захиргаа, удирдлагын газар (Б.Батбаяр)-т үүрэг болгосугай.

ДАРГА



Д.НАРАНТУЯА

1432 010106